МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 04 өдөр　　　Дугаар А/627　　　Мөрөн сум

Барилга байгууламж ашиглалтад
оруулах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2. 35.1.6, 48 дугаар зүйлийн 48.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөл аймгийн Мөрөн суманд баригдсан 15 дугаар цэцэрлэгийн барилгын дуусгалтын ажлыг хүлээж авах байнгын ашиглалтад оруулах чиг үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Б.Энхжаргал (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга)

Гишүүд:

Х.Даваасүрэн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн, Ерөнхий архитектор)

Ж.Жавзанпагма (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)

Н.Далайжаргал (Боловсрол, шинжлэх ухааны газрын Төсвийн төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн)

Н.Тайванбаяр (Мөрөн сумын Засаг дарга)

Ж.Нацагдорж (Аймгийн Онцгой байдлын газрын Гал түймрийн хяналтын ахлах байцаагч, дэд хурандаа)

Д.Мягмарсүрэн (Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга техник хяналтын улсын байцаагч)

Д.Аюушжав (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Эрчим хүчний хяналтын улсын байцаагч)

Б.Гал-Эрдэнэ (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Мэдээлэл, харилцаа холбооны хяналтын улсын байцаагч)

Г.Даваадорж (“Хөвсгөл эрчим хүч” ХХК-ийн Ерөнхий инженер)

6710011450

Д.Сүхээ (“Хөвсгөл ус суваг” ХХК-ийн Ерөнхий инженер)

Ж.Лувсанням (“Мэдээлэл холбоо сүлжээ” ХХК-ийн Ерөнхий инженер)

Э.Сумъяасүрэн (Хөвсгөл Барилга захиалагчийн хяналтын төвийн хяналтын инженер)

Ш.Нямханд (Хөвсгөл дулааны станц ТӨХК-ийн ерөнхий инженер)

Г.Дэлгэрнасан (Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн Хүртээмж нийгмийн оролцооны мэргэжилтэн)

Зураг төслийн байгууллагын төлөөлөл:

З.Азжаргал (“Грийн пайнт тийм” ХХК-ийн захирал)

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл:

С.Оюунчимэг (“Сант-Өндөр ХХК-ийн” ХХК-ийн захирал)

Ашиглагч байгууллагын төлөөлөл:

Ө.Сэлэнгэ (Мөрөн сумын 15 дугаар цэцэрлэгийн эрхлэгч)

М.Пагмажав (Мөрөн сумын 15 дугаар цэцэрлэгийн нягтлан бодогч)

Комиссын нарийн бичгийн дарга:

Э.Аззаяа (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын ахлах мэргэжилтэн)

2. Барилга байгууламжийн ажлыг хүлээж авах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, комиссын ажлын тайлан, шийдвэрийг олон нийтэд мэдээллэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Комиссын дарга (Б.Энхжаргал)-д даалгасугай.

3. Барилга байгууламжийн ажлыг хүлээж авсантай холбоотой баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасаг болон холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөхийг Комиссын нарийн бичгийн дарга (Э.Аззаяа) -д үүрэг болгосугай.

4.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т үүрэг болгосугай.

ОРЛОГЧ М.ХУЯГБААТАР